



**ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2023 ОНД
БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТӨСӨЛ:
Эдийн засаг ба бодлогын зорилтууд**

МОНГОЛБАНК

2022.10.25

Улаанбаатар хот

- I. МУЗГ, СЗХ-той хамтран хэрэгжүүлэх зорилтууд
- II. Монголбанк дангаараа хэрэгжүүлэх зорилтууд

Цар тахал, геополитикийн асуудлаас үүдэлтэй эдийн засгийн хүндрэлийг хохирол багатай даван туулж, тогтвортой байдлыг хамгаалахад мөнгө, санхүүгийн болон макро зохистой бодлогын арга хэмжээг чиглүүлнэ.

I. МУЗГ, СЗХ-той хамтран хэрэгжүүлэх зорилтууд

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай УИХ-ын тогтоолын төсөлд тусгах заалт:

- 2.1/ Гадаад төлбөрийн чадварыг сайжруулж, эдийн засгийн гадаад, дотоод тэнцвэрийг хангахад чиглэсэн төсөв, мөнгө, санхүүгийн бодлогыг уялдуулан хэрэгжүүлэх.
- 2.2/ Гадаад худалдаа, тээвэр, логистикт үүсэж буй хүндрэлийг шийдвэрлэж, түүхий эд, бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлт, хангамжийг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх;
- 2.3/Гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлд гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах таатай орчин бүрдүүлэх, банк, санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллах, валютын эх үүсвэр бүрдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- 2.4/ Уул уурхайн бус экспортын бүтээгдэхүүний боловсруулалтыг шат ахиулж, экспортыг дэмжихэд чиглэсэн гадаад худалдааны санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэх;



Төрөөс мөнгөний бодлогын талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай УИХ-ын тогтоолын төсөлд тусгах заалт:

2.5/ Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрийг үндэсний хэмжээнд үр дүнтэй хэрэгжүүлэх;

2.6/ Тогтвортой, ногоон санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлэх чиглэлд батлагдсан бодлого, хөтөлбөрийг олон улсын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх;

2.7/ Санхүүгийн тогтвортой байдлыг дэмжих, санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор иргэд, олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх дунд хугацааны төслийг боловсруулж, хэрэгжүүлэх;

2.8/ Орон сууцны ипотекийн зээлийн санхүүжилтийн тогтолцоог олон улсын сайн туршлагын дагуу бэхжүүлж, хөтөлбөрийг Монголбанкнаас Засгийн газарт 2023 онд багтаан шилжүүлэх;



II. Монголбанк дангаараа хэрэгжүүлэх зорилтууд



Мөнгөний болон макро зохистой бодлогын хүрээнд:

1.1. Хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцыг 2023 онд нэг оронтой тоонд, дунд хугацаанд +/-2 нэгж хувийн интервалд 6 хувийн орчимд тогтворжуулахад чиглэсэн мөнгөний бодлогыг зах зээлийн зарчимд тулгуурлан хэрэгжүүлнэ.

1.2. Санхүүгийн системд хуримтлагдаж болзошгүй эрсдэлийн шинжилгээ, мониторингийг сайжруулан, эрсдэл хуримтлагдахаас сэргийлэхэд чиглэсэн макро зохистой бодлогын арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлнэ.

1.3. Төв банк олон нийттэй харилцахдаа ил тод байдлын зарчим баримталж, олон улсын сайн туршлага, өөрийн орны онцлогт нийцүүлэн хөгжүүлнэ.



Анхаарал хандуулсанд баярлалаа!

Вебсайт: www.mongolbank.mn



@mongolbank_mn



@mongolbank.mn



mongolbank